

## АГУУЛГА

МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА .....	1
МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН 2018 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ.....	2
1. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ .....	4
1.1. Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого.....	5
1.2. Нэгдсэн төсвийн зарлага.....	7
1.3. Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр.....	8
1.4. Төсвийн тусгай шаардлагыг хангасан байдал .....	10
1.5. Татварын зарлага .....	12
1.6. Худалдан авсан бараа, ажил үйлчилгээ.....	13
1.7. Нэмэлт төсөв .....	15
2. МОНГОЛ УЛСЫН ТӨСӨВ.....	16
2.1. Улсын төсвийн орлого .....	16
2.2. Улсын төсвийн зарлага .....	19
2.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалт.....	20
2.4. Засгийн газрын нөөц сан.....	23
3. ИРЭЭДҮЙН ӨВ САН .....	24
4.ТӨСВИЙН ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН .....	24
5. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ .....	25
6. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ.....	26
7. ОРОН НУТГИЙН ТӨСӨВ.....	27
8. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР .....	28
8.1. Засгийн газрын дотоод үнэт цаас.....	29
8.2. Засгийн газрын гадаад үнэт цаас.....	30
8.3. Засгийн газрын гадаад зээл.....	30
8.4. Засгийн газрын өрийн баталгаа.....	31
8.5. Төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концесс .....	32

## МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018 оны гүйцэтгэл болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гарган, танилцуулж байна.

Танилцуулгад улсын төсвийн 31 ерөнхийлөн захирагчийн 828 төсөвт байгууллага, нийслэл, дүүргүүд болон 21 аймгийн 4439 төсөвт байгууллагууд, Ирээдүйн өв сан, Тогтворжуулалтын сан, Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангуудын төсвийн гүйцэтгэл хамрагдсан болно. Түүнчлэн төсвийн тухай хуулийн дагуу төсвийн гүйцэтгэлийн тайланд татварын зарлагын тайлан, худалдан авсан ажил үйлчилгээний тайлан, хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан төсөв, үр дүнгийн танилцуулга, нэмэлт төсвийн гүйцэтгэл зэргийг нэгтгэн танилцуулж байна.

### **Төсөв, эдийн засгийн голлох үзүүлэлтүүд 2018 онд:**

- Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого анх удаагаа 10 их наядыг давж, 2018 онд 10,172.8 тэрбум төгрөгт хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 27.9 тэрбум төгрөгийн ашигтай гарсан нь 2010 оноос хойш анх удаа юм.
- Төсөв, санхүүгийн зохистой бодлогыг хэрэгжүүлж, төсвийг тодотгохгүйгээр мөрдүүлж, Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас гаргахгүйгээр төсвийн санхүүжилтийг бүрэн олгож, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулсан жил боллоо.
- Төсвийн тогтворжуулалтын санд 207.0 тэрбум, Ирээдүйн өв санд 620.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн байна.
- Засгийн газраас эдийн засгийг сэргээх, идэвхжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээний үр дүнд эдийн засгийн өсөлт 2018 онд сүүлийн дөрвөн жилийн хугацаанд хамгийн өндөр буюу 7.2 хувьд хүрлээ.
- Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2018 онд 12.9 тэрбум ам.доллар болж, өмнөх оноос 22.3 хувиар өссөн бол гадаад худалдааны тэнцэл 1,136.7 сая ам.долларын ашигтай гарсан байна.

## МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН 2018 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ

**Эдийн засгийн өсөлт.** Монгол Улсын эдийн засаг 2018 онд сүүлийн дөрвөн жилийн хугацаанд хамгийн өндөр буюу 7.2 хувьд хүрлээ.

Эдийн засгийн өсөлтийг салбаруудаар авч үзвэл боловсруулах аж үйлдвэрийн салбар 2017-2018 онд 16-20 хувиар өсөж, эдийн засгийн бүтцийг сайжруулж байна.

### Хүснэгт 1. Эдийн засгийн өсөлт, салбаруудаар


	2015	2016	2017	2018
<b>Эдийн засгийн бодит өсөлт</b>	2.4	1.2	5.3	7.2
<i>Хөдөө аж ахуй</i>	10.7	6.2	1.8	4.5
<i>Үйлдвэрлэл</i>	9.9	-0.4	0.4	6.2
<i>Уул уурхай</i>	14.1	0.2	-5.5	5.7
<i>Боловсруулах аж үйлдвэр</i>	2.6	-0.8	19.9	15.7
<i>Цахилгаан дулаан</i>	4.5	2.0	5.5	8.2
<i>Барилга</i>	-0.2	-4.9	11.4	2.4
<i>Үйлчилгээ</i>	0.6	1.1	7.9	5.3
<i>Бөөний болон жижиглэн худалдаа</i>	-8.1	-2.6	6.8	3.4
<i>Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа</i>	5.1	11.5	14.2	7.6
<i>Мэдээлэл, холбоо</i>	-2.5	-6.6	13.3	7.8
<i>Үйлчилгээний бусад үйл ажиллагаа</i>	5.9	1.0	5.4	4.8
<b>Цэвэр татвар</b>	-22.1	0.5	18.5	20.1

Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо

**Ажилгүйдэл.** Эдийн засаг өсөж, бизнесийн үйл ажиллагаа сэргэлттэй байгаагийн үр дүнд 2018 онд ажиллах хүчний оролцооны түвшин 61 хувьтай, ажилгүйдлийн түвшин 7.8 хувьтай байна.

2018 онд 2017 онтой харьцуулахад ажилгүйдлийн түвшин 1 нэгжээр буурсан байна.


### График 1. Ажилгүйдлийн түвшин, жилээр



Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо

**Инфляц.** Эдийн засгийн өсөлт нэмэгдэж, иргэдийн орлого өссөнөөр хэрэглээ өссөн ч инфляц зорилтот түвшинд буюу 8.1 хувьтай гарлаа.

**График 2. Инфляцын түвшин**



Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо

**Гадаад худалдаа.** Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2018 онд 12.9 тэрбум ам.доллар болж, өмнөх оноос 22.3 хувиар өссөн бол гадаад худалдааны тэнцэл 1,136.7 сая ам.долларын ашигтай гарч өмнөх оноос 39.0 хувиар буурсан байна.

Экспортоор 7.0 тэрбум ам.долларын бараа, түүхий эд гаргасан нь өнгөрсөн оноос 13.1 хувиар өссөн байна. Уг өсөлтөд нүүрс, зэсийн баяжмал, жонш зэрэг уул уурхайн бүтээгдэхүүний экспорт өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Импортоор 5.9 тэрбум ам.долларын бараа, түүхий эд авсан нь өнгөрсөн оны мөн үеэс 35.5 хувиар өсжээ.

**Төлбөрийн тэнцэл.** Төлбөрийн тэнцэл 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр 141.7 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Данснудаар авч үзвэл, урсгал данс 2206.8 сая ам.долларын алдагдалтай гарч, алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 91 хувиар нэмэгдсэн бол хөрөнгө ба санхүүгийн данс 2182.9 сая ам.долларын ашигтай гарч, ашиг нь өмнөх оны мөн үеэс 18.5 хувиар буурсан байна.

Урсгал тэнцлийн алдагдал ийнхүү өсөхөд эдийн засгийн идэвхжил сэргэсэнтэй холбоотойгоор импорт 35.5 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Монгол Улсад 2018 онд цэвэр дүнгээр 2173.7 сая ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирсэн байна.

Оюутолгой төслийн хүрээнд 2018 онд 1,304.3 сая ам.долларын хөрөнгө оруулалт орж ирснээс 1,213.8 сая ам.долларыг далд уурхайн бүтээн байгуулалтад хөрөнгө оруулсан байна.

## 1. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого анх удаагаа 10 их наядыг давж, 2018 онд 10,172.8 тэрбум төгрөгт хүрлээ. Үүнээс Төсвийн тогтворжуулалтын санд 207.0 тэрбум төгрөг, Ирээдүйн өв санд 620.7 тэрбум төгрөгийг хуваарилж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2018 онд 9,345.1 тэрбум төгрөг болсон. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 9,317.2 тэрбум байна. Ингэснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2010 оноос хойш анх удаа 27.9 тэрбум төгрөгийн ашигтай гарсан нь Дотоодын нийт бүтээгдэхүүн<sup>1</sup> - ий 0.09 хувьтай тэнцэж байна.

**График 3. Монгол Улсын нэгдсэн төсвийн үзүүлэлт /2014- 2018 он, тэрбум төгрөг/**



**Тогтворжуулалтын сан.** Зэсийн зах зээлийн үнийн гүйцэтгэл 2018 оны турш тэнцвэржүүлсэн үнээс дээгүүр байсан тул Төсвийн тогтворжуулалтын санд 207.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

**Ирээдүйн өв сан.** Ирээдүйн өв санд 2018 онд 508.7 тэрбум төгрөг төвлөрөхөөр батлагдсанаас 620.7 тэрбум төгрөг төвлөрч, төлөвлөсөн хэмжээнээс 111.9 тэрбум

<sup>1</sup> ДНБ-ний урьдчилсан гүйцэтгэл, оны үнээр – 32,165,966.4 сая төгрөг  
Эх сурвалж Үндэсний статистикийн хороо

төгрөгөөр буюу 22 хувиар давж төвлөрсөн байна. Тус санд төвлөрсөн орлогоос Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн дагуу 100.0 тэрбум төгрөгийг улсын төсөвт шилжүүлсэн.

## 1.1. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2018 онд 9,345.1 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 26.2 хувь буюу 1,940.4 тэрбум төгрөгөөр илүү төвлөрсөн байна. Харин 2018 оны төсвийн тэнцвэржүүлсэн орлогын гүйцэтгэлийг 2017 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 2,070.2 тэрбум төгрөгөөр буюу 28.5 хувиар өссөн байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэлийг төсөв тус бүрээр нь авч үзвэл улсын төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 131.1 хувь, орон нутгийн төсвийн орлогын биелэлт 103.7 хувь, эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын биелэлт 109.3 хувь, нийгмийн даатгалын сангийн орлогын биелэлт 109.4 хувь байна.

### Хүснэгт 2. Нэгдсэн төсвийн орлого / тэрбум төгрөг /

ҮЗҮҮЛЭЛТ	2018			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>8,036.2</b>	<b>10,172.8</b>	<b>126.6</b>	<b>2,136.6</b>
<b>ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН</b>	<b>122.7</b>	<b>207.0</b>	<b>168.6</b>	<b>84.2</b>
<b>ИРЭЭДҮЙН ӨВ САН</b>	<b>508.7</b>	<b>620.7</b>	<b>122.0</b>	<b>111.9</b>
<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>7,404.7</b>	<b>9,345.1</b>	<b>126.2</b>	<b>1,940.4</b>
<b>1.Татварын орлого</b>	<b>6,356.9</b>	<b>8,227.8</b>	<b>129.4</b>	<b>1,870.9</b>
Орлогын албан татвар	1,449.1	2,091.1	144.3	642.0
Нийгмийн даатгалын орлого	1,418.8	1,638.3	115.5	219.6
Хөрөнгийн албан татвар	122.8	141.2	115.0	18.4
Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,517.3	2,195.9	144.7	678.6
Онцгой албан татвар	684.3	754.4	110.2	70.1
Тусгай зориулалтын орлого	12.1	13.1	108.3	1.0
Гадаад үйл ажиллагааны орлого	536.9	682.2	127.1	145.3
Бусад татвар, төлбөр, хураамж	615.6	711.5	115.6	95.9
<b>2.Татварын бус орлого</b>	<b>1,047.8</b>	<b>1,117.3</b>	<b>106.6</b>	<b>69.5</b>

Тайлант онд татварын орлогын бүрдүүлэлт 8,227.8 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 1,870.9 тэрбум төгрөгөөр илүү буюу 29.4 хувиар давсан байна.

Татварын орлогын төрлүүдээс орлогын албан татвар 642.0 тэрбум, нэмэгдсэн өртгийн албан татвар 678.6 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөгөөнөөс давсан нь нийт татварын орлогын гүйцэтгэлд голлон нөлөөлжээ. Орлогын албан татвар

төлөвлөгөөнөөс давж биелэхэд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөвлөгөөнөөс 585.5 тэрбум төгрөгөөр давсан нь голлон нөлөөлсөн байна. Үүнд зэсийн баяжмалын экспорт 1,436.7 мянган тонн, жилийн дундаж үнэ тонн тутамд 6,524.8 ам.долларт хүрсэн, нүүрсний экспорт 36.2 сая тоннд хүрч төсөөлсөн хэмжээнээс 30 хувиар, нүүрсний дундаж үнэ 44 хувь өссөн, арилжааны банкнуудаас аж ахуйн нэгж байгууллагуудад олгох зээлийн хэмжээ нэмэгдэж, эдийн засаг тэлснээр аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа сайжирч татварын орлого өссөн, мөн 2018 онд татварын албанаас татварын өр барагдуулах ажлыг эрчимжүүлж, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын дутуу төлөлт 166 тэрбум төгрөгийн татварын өрийг барагдуулсан зэрэг нь томоохон нөлөө үзүүлсэн байна.

Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөвлөгөөнөөс давж биелэхэд дотоодын барааны НӨАТ төлөвлөгөөнөөс 278.2 тэрбум, импортын барааны НӨАТ төлөвлөгөөнөөс 316.5 тэрбум төгрөгөөр тус тус давсан нь голлон нөлөөлжээ. Үүнд 2018 онд импортоор 5,890.0 сая ам.долларын бараа оруулсан нь өнгөрсөн оны мөн үеэс 35.6 хувиар буюу 1,547.0 сая ам.доллараар өссөн. Улмаар төгрөгөөр илэрхийлсэн импортын дүн 14,498.7 тэрбум төгрөгт хүрсэн нь импортын барааны НӨАТ өсөх гол шалтгаан болсон байна. Сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлт саарч, бизнесийн идэвхжил буурсны улмаас банкнуудын зээлийн өсөлт 2015 онд -6.7 хувьд хүрээд байсан бол 2018 онд огцом өсөж 23.5 хувиар өссөнөөр нийт эдийн засагт хэрэглээ ихсэж нэмэгдсэн өртгийн албан татварын орлого ихээхэн хэмжээгээр өссөн. Мөн нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын системийн үр дүнд татварын бүртгэл, хяналтын тогтолцоо эрс сайжирч, нэмэгдсэн өртгийн албан татварын орлого 2017 оны гүйцэтгэлээс 22.3 хувь өссөн /нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын системд бүртгэгдсэн цахим төлбөрийн баримтын тоо 2018 оны байдлаар 289.2 саяд хүрч, өмнөх оны мөн үеэс 1.7 дахин өссөн/ зэрэг нь дотоодын барааны НӨАТ төлөвлөгөөнөөс давж биелэхэд голлон нөлөөлсөн байна.

Харин татварын бус орлогын гүйцэтгэл 1,117.3 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 69.5 тэрбум төгрөгөөр илүү буюу 6.6 хувиар давсан байна. Үүнд хүү, торгуулийн орлого 59.3 тэрбум, бусад орлого 35.1 тэрбум, хувьцааны ногдол ашиг 14.2 тэрбум төгрөгөөр давж биелсэн нь голлон нөлөөлжээ.

## 1.2. НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГА

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага 2018 онд 9,317.2 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 7.2 хувь буюу 717.8 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

### Хүснэгт 3. Нэгдсэн төсвийн зарлага/ тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2018		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>10,035.1</b>	<b>9,317.2</b>	<b>-717.8</b>
<b>А. УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>7,688.0</b>	<b>7,350.3</b>	<b>-337.7</b>
<b>1. Бараа, ажил үйлчилгээний зардал</b>	<b>3,468.5</b>	<b>3,327.5</b>	<b>-141.0</b>
1. Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,900.3	1,878.9	-21.3
2. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	248.6	240.6	-8.0
3. Хангамж, бараа материалын зардал	132.8	130.5	-2.3
4. Нормативт зардал	278.3	275.6	-2.6
5. Эд хогшил, урсгал засварын зардал	78.4	77.0	-1.4
6. Томилолт, зочны зардал	29.6	26.8	-2.8
7. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	481.1	413.8	-67.3
8. Бараа үйлчилгээний бусад зардал	319.5	284.2	-35.3
<b>2. Хүү</b>	<b>1,150.7</b>	<b>1,046.4</b>	<b>-104.3</b>
<b>3.Татаас</b>	<b>245.3</b>	<b>230.0</b>	<b>-15.3</b>
<b>4. Урсгал шилжүүлэг</b>	<b>2,823.5</b>	<b>2,746.4</b>	<b>-77.1</b>
<b>Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,058.5</b>	<b>1,680.4</b>	<b>-378.0</b>
1. Барилга байгууламж	1,232.1	1,094.6	-137.5
2. Их засвар	92.2	89.9	-2.3
3. Тоног төхөөрөмж	302.5	173.9	-128.6
4. Бусад хөрөнгө	401.2	309.9	-91.3
5. Стратегийн нөөц хөрөнгө	30.5	12.1	-18.3
<b>В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>288.6</b>	<b>286.5</b>	<b>-2.1</b>
1. Эргэж төлөгдөх зээл	176.9	179.6	2.7
2. Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	111.6	106.8	-4.8

Хөрөнгийн зардал 378.0 тэрбум, бараа, ажил үйлчилгээний зардал 141.0 тэрбум, хүүгийн зардал 104.3 тэрбум, урсгал шилжүүлгийн зардал 77.1 тэрбум, татаасын зардал 15.3 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсан нь нийт зардлын гүйцэтгэлд голлон нөлөөлсөн байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлагын зарцуулагдаагүй үлдэгдлийг төсөв тус бүрээр ангилан харуулбал Улсын төсөв 93.1 хувийн гүйцэтгэлтэй буюу 528.9 тэрбум төгрөгийн дутуу зарцуулагдсан, Орон нутгийн төсөв төлөвлөсөн дүнгээс 5.9 хувь буюу 172.6 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан, Эрүүл мэндийн даатгалын



сангийн төсөв төлөвлөсөн дүнгээс 8.7 хувь буюу 29.6 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

#### Хүснэгт 4. Төсвүүдийн нийт зарлага ба цэвэр зээл / тэрбум төгрөг/

Төсвийн бүрэлдэхүүн	2017 оны	2018 оны		
	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>Нэгдсэн төсөв</b>	<b>9,017.3</b>	<b>10,035.1</b>	<b>9,317.2</b>	<b>-717.8</b>
Улсын төсөв	7,139.6	7,710.8	7,181.9	-528.9
Орон нутгийн төсөв	2,437.1	2,935.3	2,762.7	-172.6
Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв	-	341.3	311.7	-29.6
Нийгмийн даатгалын сангийн төсөв	1,890.9	1,808.3	1,814.6	6.4

### 1.3. НЭГДСЭН ТӨСВИЙН АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР

Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 27.9 тэрбум төгрөгийн ашигтай байна.

#### Хүснэгт 5. Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл /тэрбум төгрөг/

Төсвийн бүрэлдэхүүн	2017 оны	2018 оны		
	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>Нэгдсэн төсөв</b>	<b>-1,742.5</b>	<b>-2,630.3</b>	<b>27.9</b>	<b>2,658.2</b>
Улсын төсөв	-1,966.0	-2,503.4	-353.5	2,149.9
Орон нутгийн төсөв	0.1	-264.6	6.6	271.2
Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв	-	34.7	99.3	64.7
Нийгмийн даатгалын сангийн төсөв	223.4	103.0	275.4	172.5

Улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 353.5 тэрбум төгрөгийн алдагдалтай, орон нутгийн төсвийн тэнцэл 6.6 тэрбум, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тэнцэл 99.3 тэрбум, Нийгмийн даатгалын сангийн төсвийн тэнцэл 275.4 тэрбум төгрөгийн ашигтай байна.

Тайлант онд Засгийн газрын дотоод үнэт цаасны эргэн төлөлтөд 1,767.7 тэрбум төгрөг зарцуулснаас:

- Тусгай зориулалтын үнэт цаас буюу Сайн малчин, 4000 айлын орон сууц хөтөлбөрийн үнэт цаасны үндсэн төлбөрт 3.7 тэрбум төгрөгийг төлж үлдэгдэлгүй болсон.
- Улсын төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор арилжаалсан үнэт цаасны үндсэн төлбөрт 1,667.4 тэрбум төгрөг,
- Хүний хөгжил сангийн алдагдлыг нөхөх зорилгоор арилжаалсан үнэт цаасны үндсэн төлбөрт 96.6 тэрбум төгрөгийг тус тус зарцуулжээ.

Мөн гадаад үнэт цаасны үндсэн төлбөрт 667.0 тэрбум, гадаад төслийн зээлийн үйлчилгээний үндсэн төлбөрт 280.2 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан.

Ирээдүйн өв сангаас Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн дагуу 100.0 тэрбум, Хүний хөгжил сангаас үлдсэн өрийн төлбөрт 408.7 тэрбум төгрөгийг тус тус улсын төсөвт оруулсан.

**Хүснэгт 6. Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлсэн эх үүсвэр/тэрбум төг/**

Үзүүлэлт	Нэгдсэн төсөв	Улсын төсөв	Орон нутгийн төсөв	ЭМДС	НДС
<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>27.9</b>	<b>-353.5</b>	<b>6.6</b>	<b>99.3</b>	<b>275.4</b>
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-27.9	353.5	-6.6	-99.3	-275.4
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	911.4	1,390.9	-104.7	-99.3	-275.4
<b>ЗГ-ын бонд</b>	<b>-2,434.7</b>	<b>-2,434.7</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
<b>Урт хугацаат</b>	<b>-2,434.7</b>	<b>-2,434.7</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
<b>Дотоод</b>	<b>-1,767.7</b>	<b>-1,767.7</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
Үндсэн төлбөр	-1,767.7	-1,767.7	0.0	0.0	0.0
<b>Гадаад</b>	<b>-667.0</b>	<b>-667.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
Үндсэн төлбөр	-667.0	-667.0	0.0	0.0	0.0
<b>ЗГ-ын зээл</b>	<b>1,386.1</b>	<b>1,296.7</b>	<b>89.4</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
<b>Дотоод</b>	<b>408.7</b>	<b>408.7</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
Авлага	408.7	408.7	0.0	0.0	0.0
Ирээдүйн өв сангийн авлага барагдуулалт	408.7	408.7	0.0	0.0	0.0
<b>Гадаад</b>	<b>977.3</b>	<b>887.9</b>	<b>89.4</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
Төслийн зээл	502.5	413.1	89.4	0.0	0.0
Шинээр авах	782.6	693.2	89.4	0.0	0.0
Үндсэн төлбөр	-280.2	-280.2	0.0	0.0	0.0
<b>Хөтөлбөрийн зээл</b>	<b>474.8</b>	<b>474.8</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
Шинээр авах	474.8	474.8	0.0	0.0	0.0
Ирээдүйн өв сангийн шилжүүлэг	100.0	100.0	0.0	0.0	0.0
Өмч хувьчлал	9.4	0.7	8.6	0.0	0.0

## 1.4. ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГЫГ ХАНГАСАН БАЙДАЛ

**Төсвийн орлогын тусгай шаардлага:** Монгол Улсын 2018 оны төсвийн орлогын төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасан “Төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцох” тусгай шаардлагын дагуу боловсруулан батлуулж, төсвийн жилийн турш уг хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан ажиллалаа.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3-т заасны дагуу гол нэр төрлийн эрдэс баялгийн 2018 онд баримтлах тэнцвэржүүлсэн үнийг Олон улсын валютын сан болон ашигт малтмалын бүтээгдэхүүний үнийн төсөөлөл хийдэг олон улсын нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагаас гаргасан өмнөх 20 жилийн үнийн дундаж болон тухайн төсвийн жил, түүний дараах 3 жилийн дундаж үнийн төсөөллийг дундажлан тус тус тооцсон.

Эрдэс бүтээгдэхүүний үнийн төсөөллийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т заасан зарчмын дагуу олон улсад нийтлэг хэрэглэдэг “Bloomberg” мэдээллийн эх сурвалжаас авч ашиглаж 2018 онд нэг тонн зэсийн тэнцвэржүүлсэн үнийг 5,106.9 ам.доллар байхаар тооцож, зэсийн орлогоос Төсвийн тогтворжуулалтын санд 122.7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн.

### Хүснэгт 7. 2018 он зэсийн зах зээлийн үнэ

Бүтээгдэхүүний төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Зэс, ам.доллар	6.430.0	6,524.8	94.8

Зэсийн зах зээлийн үнийн гүйцэтгэл 2018 оны турш тэнцвэржүүлсэн үнээс буюу 5,106.9 ам.доллараас дээш байсан тул Төсвийн тогтворжуулалтын санд 207.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

**Төсвийн тэнцлийн тусгай шаардлага:** Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2-т “нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх” гэж заасныг 2013 оны төсвийн жилээс хэрэгжүүлж эхэлсэн.

Улсын Их Хурлаас төсвийн нэгдмэл байдлыг хангах зорилгоор Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2-ийн тусгай шаардлагад 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан. Үүнд “Энэ хуулийн 6.1.2-т заасан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2017 онд 10.4 хувиас, 2018 онд 9.5 хувиас, 2019 онд 6.9 хувиас, 2020 онд 5.1 хувиас, 2021 онд 3.6 хувиас, 2022 онд 2.8 хувиас тус тус хэтрүүлэхгүй, 2023 оны төсвийн жилээс эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн

дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна..” гэж тусгасан.

#### Хүснэгт 8. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн гүйцэтгэл

		2018 он
1	Хуулиар тогтоосон хязгаар	-9.5%
2	Гүйцэтгэл	0.09%

2018 оны төсвийн гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн тэнцэл 27.9 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 0.09 хувьтай тэнцэж байгаа нь тус шаардлагыг хангаж байна.

**Зарлагын өсөлтийн тусгай шаардлага:** Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.3-т “тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх” гэж заасан.

#### Хүснэгт 9. Зарлагын өсөлтийн үзүүлэлтүүд

		2018 он
1	Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь	5.4%
2	Тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь	12.1%
3	Тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дундаж	21.0%

**Өрийн тусгай шаардлага:** Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т төсөвт баримтлах өрийн тусгай шаардлагыг тодорхойлсон. Улмаар, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулж, Улсын өрийн тухай төсвийн тусгай шаардлагыг 2018 оны төсвийн жилд 80.0 хувиас хэтрүүлэхгүй байхаар хуульчилсан.

#### Хүснэгт 10. Засгийн газрын өрийн үзүүлэлтүүд

ӨРИЙН БҮТЭЦ, ӨРИЙН ХЭРЭГСЭЛ		2018.12.31
I. Засгийн газрын дотоод өр		1,564.7
1.1	Үнэт цаас	1,564.7
II. Засгийн газрын гадаад өр		18,865.6
2.1	Үнэт цаас	7,664.5
2.2	Зээл	11,201.1
III. Засгийн газрын өрийн баталгаатай зээллэг		1,130.7
IV. Барих-шилжүүлэх концесс		806.0
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (I+II+III+IV)		22,367.0
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)		18,955.9
<b>Хуулиар тогтоосон өрийн хязгаар</b>		<b>80.0%</b>
<b>Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ</b>		<b>58.9%</b>

Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 2018 оны эцэст 22,367.0 тэрбум төгрөг, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл 18,955.9 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 58.9 хувьтай тэнцүү байгаа нь өрийн тухай тусгай шаардлагыг бүрэн хангаж байна.

## 1.5. ТАТВАРЫН ЗАРЛАГА

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.25-д “татварын зарлага” гэж татварын хуулиар тухайн жилд татвар төлөгчид олгох татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хэлнэ, мөн Татварын ерөнхий хуулийн 3 дугаар зүйлд татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг гагцхүү хуулиар ногдуулахаар тус тус заасан бөгөөд одоогийн байдлаар 250 гаруй төрлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн заалтууд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Хууль тогтоомжийн дагуу олгосон татварын хөнгөлөлт, чөлөөлөлт 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр 857.5 тэрбум төгрөг<sup>2</sup> буюу нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 9.2 хувьд хүрэхээр байна. Татварын зарлагын хэмжээг татвар, гаалийн байгууллагаар харуулбал дараах байдалтай байна.

**Хүснэгт 11. Татварын зарлагын хэмжээ/ тэрбум төгрөг/**

Байгууллага	2018 он	Бүтэц хувиар
<b>Татварын байгууллага</b>	<b>496.7</b>	<b>57.9%</b>
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	240.6	28.1%
Хувь хүний орлогын албан татвар	142.9	16.7%
Нэмэгдсэн өртгийн албан татвар	113.3	13.2%
<b>Гаалийн байгууллага</b>	<b>360.7</b>	<b>42.1%</b>
Гаалийн албан татвар	69.5	8.1%
Онцгой албан татвар	130.0	15.2%
Нэмэгдсэн өртгийн албан татвар	161.2	18.8%
<b>Нийт татварын зарлага</b>	<b>857.5</b>	<b>100.0%</b>

Хүснэгтээс харахад нийт татварын зардал буюу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн 57.9 хувь буюу 496.7 тэрбум төгрөгийг татварын алба, 42.1 хувь буюу 360.7 тэрбум төгрөгийг гаалийн байгууллага эдлүүлсэн байна.

<sup>2</sup> Татварын зарлагын дүнд НӨАТ-ын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.13 дахь хэсэгт заасан экспортын уул уурхайн бүтээгдэхүүний албан татварын чөлөөлөлт хамрагдаагүй болно. Энэхүү зохицуулалт нь татварын орлогыг нэмэгдүүлэх зохицуулалт тул татварын зарлага хэсэгт хамруулаагүй болно. Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газар гадаад улсын засгийн газартай байгуулсан давхар татварын гэрээний дагуу үзүүлсэн хөнгөлөлт, чөлөөлөлтийг энэ тооцоонд оруулсан болно.

## 1.6. ХУДАЛДАН АВСАН БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан тухай 2018 оны нэгдсэн тайлангаас үзэхэд Монгол Улсын хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр нийт 1,588.1 тэрбум төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

### Хүснэгт 12. Нийт худалдан авалтад тендер шалгаруулалтын журмыг хэрэглэсэн байдал/тэрбум төгрөг/

Д/д	Худалдан авалтын төрөл	Тендер шалгаруулалт зарласан тоо	Дүн	Хувь
1	Нээлттэй тендер шалгаруулалтын журмаар	2200	1,265.0	79.7
2	Шууд гэрээ байгуулах аргаар	229	132.1	8.3
3	Харьцуулалтын аргаар	3243	102.7	6.5
4	Шууд худалдан авалтаар	4392	39.2	2.5
5	Хязгаарлагдмал тендер шалгаруулалтын аргаар	19	35.3	2.2
6	Зөвлөх үйлчилгээ	134	10.8	0.7
7	Ерөнхий гэрээгээр	17	2.1	0.1
8	Олон нийтийн оролцооны аргаар	85	0.8	0.1
<b>Нийт худалдан авалт</b>		<b>10319</b>	<b>1,588.1</b>	<b>100</b>

Засгийн газрын 2018 оны 129 дүгээр тогтоолоор “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д заасан босго үнэд нэмэлт оруулж, зөвлөх болон зөвлөхөөс бусад үйлчилгээний шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг 10 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон. Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын дагуу зохион байгуулах босго үнийг өөрчилсөнтэй холбогдуулан тайлант хугацаанд зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалтын тоо буурсан болно.

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2018 онд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланд Сангийн сайдын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах” журмын 3 дугаар хавсралтад тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээг хийлээ.

Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр 2018 онд нийт 2,211.1 /хоёр их наяд хоёр зуун арван нэг/ тэрбум төгрөгийн өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөж, нийт 1,588,1 тэрбум төгрөгийн өртөг бүхий гэрээ байгуулж ажилласан байна. Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх шинээр эхлэх төсөл, арга хэмжээнд 766.2 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд 659.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож гүйцэтгэл 86.1 хувьтай байсан болно. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2018 оны худалдан авах ажиллагаанд өгсөн үнэлгээний дүнгээр Орхон аймгийн Засаг дарга 93.3 хувь

буюу “Маш сайн”, Батлан хамгаалахын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Зам тээврийн хөгжлийн сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Ерөнхий сайдын ажлын алба, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Авлигатай тэмцэх газрын дарга, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийн багц, Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Говь-сүмбэр, Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Дундговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Хөвсгөл, Хэнтий аймгуудын Засаг дарга нар 80-89 хувь буюу “Сайн”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Гадаад харилцааны сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайд, Эрчим хүчний сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Нийслэлийн Засаг дарга, Баян-Өлгий, Булган, Өвөрхангай, Өмнөговь, Завхан, Ховд аймгийн Засаг дарга нар, Шадар сайд, Улсын ерөнхий прокурор, Үндсэн хуулийн цэцийн дарга, Үндэсний статистикийн газрын дарга, Шүүхийн ерөнхийн ерөнхий зөвлөлийн дарга, Ерөнхий аудитор нар 60-79 хувь буюу “Хангалттай”, Барилга хот байгуулалтын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Эрчим хүчний сайд, Сонгуулийн ерөнхий хорооны дарга нар 40-59 хувь буюу “Хангалтгүй” үнэлгээ тус тус авсан байна. Улсын хэмжээнд 2018 оны худалдан авах ажиллагааны хуулийн хэрэгжилт нийт 75 хувь буюу “Хангалттай” гэсэн үнэлгээ авч байна.

Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь гэрээ байгуулах эрх олгосноос хойш ажлын 5 хоногийн дотор тендерт оролцогч нараас ирүүлсэн гомдлыг хүлээн авч 14 хоногийн дотор хянан хариу өгөх үүрэгтэй байдаг. 2018 онд тендер шалгаруулалттай холбоотой нийт 1446 гомдол холбогдох байгууллагуудад гарсан байх бөгөөд үүнээс 198 гомдол буюу 13.7 хувь нь тендерийн нээлт хийхээс өмнөх шатанд, 1187 буюу 82.1 хувь нь захиалагчийн шийдвэрт, 61 буюу 4.2 хувь нь гэрээнд гарын үсэг зурагдсаны дараа эсвэл Сангийн яамны шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй үндэслэлээр шүүхэд тус тус хандсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10<sup>1</sup> дугаар зүйл болон Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолын 2-т заасан дотоодын үйлдвэрээс бараа худалдан авах заалтын хэрэгжилтийг төсвийн ерөнхийлөн захирагчдын ирүүлсэн тайлангаас үзэхэд 2018 онд дотоодод үйлдвэрлэсэн 12 нэр, төрлийн бараанаас 92.5 тэрбум төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

## 1.7. НЭМЭЛТ ТӨСӨВ

Нэмэлт төсөвт 2018 онд 312.6 тэрбум төгрөгийн эх үүсвэр төвлөрсөн байна.

Нийт эх үүсвэрийн 184.8 тэрбум төгрөг буюу 59.1 хувь нь төсвийн эх үүсвэрээс, 127.8 тэрбум төгрөг буюу 40.9 хувь нь төсвийн бус эх үүсвэрээс санхүүжигдсэн байна. Эх үүсвэрийг ангилан үзэхэд:

- Дээд шатны төсөв захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 122.5 тэрбум төгрөг;
- Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламжаар 48.6 тэрбум төгрөг;
- Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 79.2 тэрбум төгрөг;
- ЗГ-ын болон Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 62.3 тэрбум төгрөг тус тус төвлөрсөн байна.

Нэмэлт төсвөөр 2018 онд 314.8 тэрбум төгрөг зарцуулагдсан байна. Үүнээс Батлан хамгаалахын сайдын зарлагын гүйцэтгэл 56.0 тэрбум төгрөг буюу нийт нэмэлт төсвийн зарлагын гүйцэтгэлийн 17.8 хувь, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын зарлага 30.7 тэрбум төгрөг буюу 9.7 хувь, Эрүүл мэндийн сайдын гүйцэтгэл 28.3 тэрбум төгрөг буюу 9.0 хувь, Шадар сайдын гүйцэтгэл 20.6 тэрбум төгрөг буюу 6.6 хувь, Хууль зүй, дотоод хэргийн сайдын гүйцэтгэл 17.9 тэрбум төгрөг буюу 5.7 хувь, Хүнс, хөдөө аж ахуйн сайд 16.6 тэрбум төгрөг буюу 5.3 хувь, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд 16.5 тэрбум төгрөг буюу 5.3 хувийн гүйцэтгэл тус тус эзэлж байна.

Нэмэлт төсвийн нийт зарлагын 25.5 хувь буюу 80.2 тэрбум төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд, 24.6 хувь буюу 77.6 тэрбум төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт, 12.8 хувь буюу 40.4 тэрбум төгрөгийг томилолтын зардалд, 7.8 хувь буюу 24.6 тэрбум төгрөгийг эд хогшил, урсгал засварын зардалд, 6.6 хувь буюу 20,6 тэрбум төгрөгийг цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардалд, 3.8 хувь буюу 11.9 тэрбум төгрөгийг хангамж, бараа материалын зардалд, 3.2 хувь буюу 10.1 тэрбум төгрөгийг норматив зардалд тус тус зарцуулсан байна.



## 2. МОНГОЛ УЛСЫН ТӨСӨВ

Монгол Улсын төсөв нь нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн бөгөөд Монгол Улсын ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, яамд болон тэдгээрийн харьяа байгууллагуудын бүрдүүлэн зарцуулах төсөв юм.

Монгол Улсын 2018 оны төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 6,828.4 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 7,181.9 тэрбум төгрөгт хүрч, төсвийн тэнцэл 353.5 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.

### 2.1. УЛСЫН ТӨСВИЙН ОРЛОГО

Монгол Улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2018 онд 6,828.4 тэрбум төгрөгт хүрч, 131.1 хувийн гүйцэтгэлтэй буюу төлөвлөгөөнөөс 1,621.0 тэрбум төгрөгөөр давсан, харин өмнөх оны гүйцэтгэлээс 1,654.7 тэрбум төгрөгөөр буюу 32.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

#### Хүснэгт 13. Улсын төсвийн орлогын гүйцэтгэл/тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2017 оны	2018 оны		
	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>5,857.1</b>	<b>5,838.8</b>	<b>7,656.1</b>	<b>1,817.2</b>
<b>ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН</b>	<b>325.7</b>	<b>122.7</b>	<b>207.0</b>	<b>84.2</b>
<b>ИРЭЭДҮЙН ӨВ САН</b>	<b>357.7</b>	<b>508.7</b>	<b>620.7</b>	<b>111.9</b>
<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>5,173.7</b>	<b>5,207.3</b>	<b>6,828.4</b>	<b>1,621.0</b>
<b>Татварын орлого</b>	<b>3,987.2</b>	<b>3,835.0</b>	<b>5,430.6</b>	<b>1,595.6</b>
Орлогын албан татвар	962.1	691.4	1,276.9	585.5
Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,618.5	1,517.3	2,195.9	678.6
Онцгой албан татвар	519.7	684.3	754.4	70.1
Тусгай зориулалтын орлого	12.4	12.1	13.1	1.0
Гадаад үйл ажиллагааны орлого	512.4	536.9	682.2	145.3
Бусад татвар, төлбөр, хураамж	362.1	393.0	508.1	115.0
<b>Татварын бус орлого</b>	<b>1,186.5</b>	<b>1,372.3</b>	<b>1,397.7</b>	<b>25.4</b>
Нийтлэг татварын бус орлого	738.0	760.2	810.8	50.6
Тусламжийн орлого	253.0	322.8	297.7	-25.2
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	195.4	289.2	289.2	0.0

Монгол Улсын 2018 оны эдийн засгийн бодит өсөлтийг 4.2 хувь байхаар тооцсон боловч Монгол Улсын эдийн засаг, тэр дундаа орлогын дийлэнх хэсгийг бүрдүүлдэг уул уурхайн салбарын бодит өсөлт төсөөлсөн хэмжээнээс сайжирч эдийн засаг дахь бодит өсөлт 2018 онд 7.2 хувьд хүрсэн.

Улсын төсвийн орлогын гүйцэтгэл төлөвлөгөөнөөс давж биелэхэд уул уурхайн эрдэст бүтээгдэхүүний үнийн өсөлт болон түүний экспортын биет хэмжээ нэмэгдсэн, 2018 онд татварын албанаас татварын өр барагдуулах ажлыг

эрчимжүүлж, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын дутуу төлөлт 166 тэрбум төгрөгийн татварын өрийг барагдуулсан зэрэг нь нөлөөлсөн байна.

#### Хүснэгт 14. Улсын төсвийн зарим нэр төрлийн орлогын гүйцэтгэл, тайлбар

Орлогын төрөл	2017 оны гүйцэтгэл	2018 оны төлөвлөгөө	2018 оны гүйцэтгэл	Зөрүү	
	1	2	3	3-2	
<b>Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн</b>	<b>5,173.68</b>	<b>5,207.34</b>	<b>6,828.37</b>	<b>1,621.04</b>	Тайлбар
Төлөвлөгөөнөөс давсан голлох орлогууд					
ААН-ын орлогын албан татвар	962.14	691.40	1,276.93	585.53	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөвлөгөөнөөс давж биелэхэд зэсийн баяжмалын экспорт 1,436.7 мянган тоннд хүрсэн бөгөөд жилийн дундаж үнэ тонн тутамд 6,524.8 ам.долларт хүрсэн, нүүрсний экспорт 36.2 сая тоннд хүрч төсөөлсөн хэмжээнээс 30 хувиар, нүүрсний дундаж үнэ 44 хувь өссөн, 2015-2017 онд арилжааны банкнуудаас аж ахуйн нэгж байгууллагуудад олгосон зээлийн дундаж өсөлтийн хэмжээ 190 орчим тэрбум төгрөг байсан бол 2018 онд 1.1 их наяд төгрөгт хүрсэн нь аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа сайжирч татварын орлого өссөн, мөн 2018 онд татварын албанаас татварын өр барагдуулах ажлыг эрчимжүүлж, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын дутуу төлөлт 166 тэрбум төгрөгийн татварын өрийг барагдуулсан зэрэг нь томоохон нөлөө үзүүлсэн байна.
Импортын барааны НӨАТ	1,031.77	1,095.00	1,411.50	316.50	2018 онд импортоор 5,890.0 сая ам.долларын бараа оруулсан нь өнгөрсөн оны мөн үеэс 35.6 хувиар буюу 1,547.0 сая ам.доллараар өссөн. Улмаар төгрөгөөр илэрхийлсэн импортын дүн 14,498.7 тэрбум төгрөгт хүрсэн нь импортын барааны НӨАТ өсөх гол шалтгаан болсон байна.
Дотоодын барааны НӨАТ	734.28	620.00	898.25	278.25	Сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлт саарч, бизнесийн идэвхжил буурсны улмаас банкнуудын зээлийн өсөлт 2017 онд 9.5 хувьд хүрээд байсан бол

					2018 онд огцом өсөж 23.5 хувиар өссөнөөр нийт эдийн засагт хэрэглээ ихсэж нэмэгдсэн өртгийн албан татварын орлого ихээхэн хэмжээгээр өссөн. Мөн нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын системийн үр дүнд татварын бүртгэл, хяналтын тогтолцоо эрс сайжирч, нэмэгдсэн өртгийн албан татварын орлого 2017 оны гүйцэтгэлээс 22.3 хувь өссөн /нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын системд бүртгэгдсэн цахим төлбөрийн баримтын тоо 2018 оны байдлаар 289.2 саяд хүрч, өмнөх оны мөн үеэс 1.7 дахин өссөн/ зэрэг нь дотоодын барааны НӨАТ төлөвлөгөөнөөс давж биелэхэд голлон нөлөөлсөн байна.
Импортын гаалийн албан татвар	512.35	536.91	682.21	145.30	Татвартай импортын 35.9 хувийн өсөлт, төгрөгийн ам.доллартай харьцах харьцаа 1.2 хувиар суларсан зэрэг нь гаалийн байгууллагаас улсын төсөвт оруулах орлого, тухайлбал импортын гаалийн албан татвар болон НӨАТ-ын орлого давж биелэхэд голлон нөлөөлсөн байна.
Суудлын автомашины онцгой албан татвар	88.53	96.23	214.17	117.94	Хэрэглээний зээлийн дээд хугацаанд тавьж буй хязгаарлалт 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан өнгөрсөн оны автомашины импорт, борлуулалтын хэмжээ огцом өссөн нь суудлын автомашины онцгой албан татвар өсөхөд голлон нөлөөлсөн байна. Тухайлбал, тайлант хугацаанд онцгой албан татвартай суудлын автомашин 63,601.0 ширхэг импортолсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 36,579.0 ширхгээр буюу 135.4 хувиар өссөн байна.
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	192.62	248.18	320.61	72.44	Зэсийн баяжмалын экспорт төлөвлөгөөнөөс 70.7 мянган тонноор их буюу 1,436.7 мянган тоннд хүрч, жилийн дундаж үнэ тонн тутамд төлөвлөгөөнөөс 94.8 ам.доллараар их буюу 6,524.8 ам.долларт хүрсэн. Мөн нүүрсний экспорт төлөвлөгөөнөөс 8.3 сая тонноор их буюу 36.2 сая тоннд хүрч, жилийн дундаж үнэ тонн тутамд төлөвлөгөөнөөс 23.6 ам.доллараар их буюу 77.3 ам.долларт хүрсэн зэрэг нь ашигт малтмалын нөөц

					ашигласны төлбөр төлөвлөгөөнөөс давж биелэхэд голлон нөлөөлсөн байна.
Төлөвлөгөөнөөс буурсан гол орлого					
Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар	124.60	295.43	213.49	(81.94)	Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 26 дугаар тогтоолоор октаны хэмжээ 95-аас доош автобензины онцгой албан татварын тонн тутамд ногдуулах хувь хэмжээг тэглэсэн нь автобензин, дизелийн түлшний онцгой албан татварын орлого буурахад голлон нөлөөлсөн байна.

## 2.2. УЛСЫН ТӨСВИЙН ЗАРЛАГА

Монгол Улсын төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2018 онд 7,181.9 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгөөнөөс 528.9 тэрбум төгрөг буюу 6.9 хувиар бага гарсан байна. Харин өмнөх оны гүйцэтгэлээс 42.3 тэрбум төгрөгөөр буюу 0.6 хувиар өссөн байна.

Улсын төсвийн урсгал зардалд 5,713.5 тэрбум, хөрөнгийн зардалд 1,206.4 тэрбум, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлд 261.9 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

### Хүснэгт 15. Улсын төсвийн зарлагын гүйцэтгэл/тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2017 оны	2018 оны		
	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>7,139.6</b>	<b>7,710.8</b>	<b>7,181.9</b>	<b>-528.9</b>
<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	<b>6,846.7</b>	<b>7,457.4</b>	<b>6,920.0</b>	<b>-537.4</b>
УРСГАЛ ЗАРДАЛ	5,524.2	5,973.2	5,713.5	-259.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,901.8	2,106.2	1,993.7	-112.5
ХҮҮ	1,156.5	1,150.7	1,046.4	-104.3
ТАТААС	647.8	702.5	698.7	-3.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,818.2	2,013.8	1,974.7	-39.1
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,322.4	1,484.2	1,206.4	-277.8
Дотоод эх үүсвэрээр	1,322.4	1,484.2	1,206.4	-277.8
<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>293.0</b>	<b>253.4</b>	<b>261.9</b>	<b>8.6</b>

Улсын төсвөөс Нийгмийн даатгалын санд 609.8 тэрбум төгрөгийн татаас, орон нутгийн төсөвт санхүүгийн дэмжлэгээр 180.7 тэрбум төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилтэд 1,119.1 тэрбум төгрөг, орон нутгийн хөгжлийн санд хуваарилах орлогын шилжүүлгээр 88.6 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.

### 2.3. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Монгол Улсын 2018 оны төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 754 төсөл, арга хэмжээний 766.2 тэрбум төгрөг батлагдсанаас, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 749 төсөл, арга хэмжээний 683.3 тэрбум төгрөг, “Барих-шилжүүлэх” нөхцөлтэй концессын гэрээ байгуулсан төслүүдийн эргэн төлөлтөд 5 төсөл, арга хэмжээний 82.8 тэрбум төгрөг тус тус батлагдсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд 749 төсөл, арга хэмжээнээс 636 төсөл, арга хэмжээ шинээр хэрэгжиж, 113 төсөл, арга хэмжээ нь он дамжин хэрэгжиж байгаа бөгөөд санхүүжилтийн гүйцэтгэл жилийн эцсийн байдлаар 659.2 тэрбум төгрөг буюу 86.0 хувийн биелэлттэй байна.

#### Хүснэгт 16. Сүүлийн 5 жилийн Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл/тэрбум төгрөг/

№	Он	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь
1	2014	1,179.5	966.8	82.0%
2	2015	357.9	246.4	68.8%
3	2016	1,046.5	975.1	93.2%
4	2017	779.3	714.8	91.7%
5	2018	766.2	659.4	86.1%
<b>Нийт дүн</b>		<b>4,129.40</b>	<b>3,562.50</b>	<b>86.3%</b> <i>/5 жилийн дундаж/</i>

Үүнээс, 2018 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг төсвийн ерөнхийлөн захирагчдаар авч үзвэл дараах байдалтай байна.

## Хүснэгт 17. 2018 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл /сая төгрөг/

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсөвт өртөг	2018 онд санхүүжих дүн	Төсөл, арга хэмжээний тоо	Гүйцэтгэлийн дүн	Үлдэгдэл	Ашиглагдаагүй эх үүсвэрийн ангилал		Гүйцэтгэлийн хувь
							Төндөрийн хэмнэлт	Ажлын гүйцэтгэл гараагүй	
I	Монгол улсын ерөнхийлөгчийн тамгын газрын дарга	770.7	770.7	3	754.3	16.4	16.4	-	97.9
II	Монгол улсын их хурлын дарга	1,913.3	1,913.3	1	1,701.4	211.9	211.9	-	88.9
III	Монгол улсын ерөнхий сайд	5,685.3	3,762.8	8	2,709.9	1,052.9	223.4	829.5	72.0
IV	Монгол улсын шадар сайд	12,695.2	6,006.4	12	5,843.3	163.1	14.0	149.1	97.3
V	Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга	23,920.9	11,881.8	32	10,459.8	1,422.0	671.0	751.0	88.0
VI	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	12,789.5	10,389.5	13	10,117.9	271.6	271.6	0.0	97.4
VII	Гадаад харилцааны сайд	1,800.0	1,800.0	3	1,800.0	-	-	-	100.0
VIII	Сангийн сайд	78,098.1	32,810.0	14	20,700.0	12,110.0	3,023.1	9,086.9	63.1
IX	Хууль зүй, дотоод хэргийн сайд	59,590.9	37,390.0	40	37,204.3	185.7	179.1	6.7	99.5
X	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	36,723.3	17,340.0	25	16,852.6	487.4	457.3	30.1	97.2
XI	Батлан хамгаалахын сайд	19,417.4	3,599.5	4	3,334.8	264.7	264.7	-	92.7
XII	Барилга, хот байгуулалтын сайд	430,501.9	80,338.4	78	67,408.4	12,930.1	1,777.5	11,152.5	83.9
XIII	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	739,859.9	262,817.6	325	222,404.6	40,413.1	4,182.2	36,230.9	84.6
XIV	Зам, тээврийн хөгжлийн сайд	342,951.3	80,797.0	64	68,408.6	12,388.3	1,148.6	11,239.7	84.7
XV	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	3,980.0	3,980.0	5	3,623.1	356.9	213.8	143.1	91.0
XVI	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	41,521.3	27,818.5	32	22,074.9	5,743.6	1,748.5	3,995.1	79.4
XVII	Эрчим хүчний сайд	151,489.7	37,661.9	20	36,905.0	756.9	756.9	-	97.99
XVIII	Эрүүл мэндийн сайд	193,319.4	60,754.8	63	46,422.7	14,332.0	1,382.7	12,949.3	76.41
XIX	Авлигатай тэмцэх газрын дарга	195.6	195.6	1	195.6	0.0	0.0	-	100.0
XX	Үндсэн хуулийн цэцийн дарга	340.0	340.0	1	339.4	0.6	0.6	-	99.8
XXI	Улсын ерөнхий прокурор	1,562.0	452.0	4	450.8	1.2	1.2	0.0	99.7
XXII	Монгол улсын ерөнхий аудитор	500.0	500.0	1	498.0	2.0	2.0	-	99.6
	<b>НИЙТ</b>	<b>2,159,625.7</b>	<b>683,319.8</b>	<b>749</b>	<b>580,209.4</b>	<b>103,110.4</b>	<b>16,546.5</b>	<b>86,563.9</b>	<b>84.9</b>

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд дараах барилга байгууламж ашиглалтад орсон. Үүнд:

- Сургуулийн барилга 10,
- Цэцэрлэг 22,
- Дотуур байр 5,
- Соёлын барилга байгууламж 5,
- Сургуулийн заал 4,
- Спортын барилга байгууламж 1,
- Эмнэлгийн барилга, өргөтгөл 11,
- Төрийн үйлчилгээний конторын барилга 59,
- Хатуу хучилттай авто зам 248.7 км,
- Гүүрийн байгууламж 793.4 урт/метр,
- 0.4-15 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын шинэчлэл 10 сум,
- Дулааны шугам, сүлжээний өргөтгөл, шинэчлэл 6.2 км,
- Аврах гал унтраах ангийн барилга 3,
- Улсын хэмжээнд 154 худаг зэргийг ашиглалтад оруулж хүлээлгэн өгсөн байна.

#### **Концессын эргэн төлөлт:**

Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2018 онд санхүүжүүлэх “барих-шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ барилга, байгууламжийн эргэн төлөлтийн жагсаалтаар концессын гэрээний дагуу 5 төсөл, арга хэмжээнд 82.8 тэрбум төгрөгийн санхүүжилт төлөвлөснөөс аудитын дүгнэлтэд үндэслэн 79.0 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлж, гүйцэтгэл 99.0 хувьтай байна. Концессын гэрээний дагуу 2017 онд нийт авто зам 269.2 км, гүүрний байгууламж 1, Дархан-Уул, Хөвсгөл аймагт ашиглалтад орсон 2 цэцэрлэгийн барилгын эргэн төлөлтийг бүрэн төлсөн.

## 2.4. ЗАСГИЙН ГАЗРЫН НӨӨЦ САН

Монгол Улсын Засгийн газрын нөөц сангийн 2018 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлснээс гадна төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 6.3.1-д “Энэ хуулийн 6.1.2-т заасан эх үүсвэрийг нь 100 хувь төсвийн хөрөнгөөр бүрдүүлэх тусгай санд Засгийн газрын нөөц сан хамаарна” гэж заасны дагуу Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулиар Сангийн сайдын 2018 төсвийн багцад Засгийн газрын нөөц санг тусгасан. Засгийн газрын нөөц сангийн гүйцэтгэлийг дараах хүснэгтэд харуулав.

### Хүснэгт 18. ЗГ-ын нөөц сангийн гүйцэтгэл /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Дүн
2018 оны ЗГ-ын нөөц сангийн төлөвлөгөө	25.0
Засгийн газрын тогтоолын нийт дүн	27.5
Үүнээс: 2017 оны шийдвэрээр	2.4
2018 оны шийдвэрээр	22.4
Санхүүжүүлсэн нийт дүн	24.8
Санхүүжүүлээгүй дүн	-
Шийдвэрийн үлдэгдэл	2.5
Санхүүжүүлээгүй хүлээгдэж буй гүйцэтгэл	-

Засгийн газрын нөөц сангийн 2018 оны төлөвлөгөө 25.0 тэрбум төгрөгөөр батлагдсанаас 27.5 тэрбум төгрөгийг зарцуулахаар Засгийн газрын шийдвэрүүд гарсан байна. Засгийн газрын шийдвэрүүдийн дагуу нийт 24.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, 99.1 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9<sup>1</sup>.2.3-т Засгийн газрын нөөц сангийн болон Эрсдэлийн сангийн тухайн төсвийн жилийн зарцуулагдаагүй чөлөөт эх үүсвэр нь Төсвийн тогтворжуулалтын сангийн эх үүсвэр байхаар заасны дагуу Засгийн газрын нөөц сангийн зарцуулагдаагүй үлдэгдэл болох 0.2 тэрбум төгрөгийг тус санд төвлөрүүлсэн.



### 3. ИРЭЭДҮЙН ӨВ САН

Ирээдүйн өв сангийн тухай хууль 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүчин төгөлдөр болж, хэрэгжиж эхэлсэн. Ирээдүйн өв сангийн орлогын үндсэн эх үүсвэр нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 65 хувь, ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувьцааны ногдол ашиг юм.

Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д санд төвлөрүүлэх хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгаж батална гэж заасан бөгөөд тус санд 2018 онд 508.7 тэрбум төгрөг төвлөрөхөөр батлагдаж, 620.7 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн хэмжээнээс 111.9 тэрбум төгрөгөөр буюу 22 хувиар давж төвлөрсөн байна.

Ирээдүйн өв сан нь Хүний хөгжил сангийн боловсронгуй хэлбэр байхаар байгуулагдсан бөгөөд Хүний хөгжил санг Ирээдүйн өв санд шилжүүлж байгаатай холбоотойгоор Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг Улсын Их Хурлаас баталсан. Уг хуулийн дагуу Хүний хөгжил сангийн нийт 1,071.9 тэрбум төгрөгийн өр улсын төсөвт шилжиж, Ирээдүйн өв сангаас авах авлагаар бүртгэгдсэн. 2017 онд уг өр төлбөрөөс 196.9 тэрбум төгрөгийг барагдуулж, уг өрийн үлдэгдэл 875.0 тэрбум төгрөг болсон.

2018 онд тус санд төвлөрсөн орлогоос Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн дагуу 100.0 тэрбум төгрөгийг улсын төсөвт шилжүүлж, 408.7 тэрбум төгрөгийг Хүний хөгжил сангаас үлдсэн өрийн төлбөрт шилжүүлж, дээрх өрийн үлдэгдэл 466.3 тэрбум төгрөг болсон.

### 4. ТӨСВИЙН ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН

Төсвийн тогтворжуулалтын сан нь эдийн засгийн мөчлөг болон эрдэс, түүхий эдийн дэлхийн зах зээл дээрх үнийн хэлбэлзлээс шалтгаалсан төсвийн орлогын хэлбэлзлийг бууруулах, тогтворжуулах зорилготой баялгийн сан бөгөөд төсвийн алдагдлыг нөхөх зориулалтаар үнэ тогтвортой буюу өсөлттэй үед хуримтлуулдаг.

Уг санд 2011 оны 2 дугаар сараас хуримтлал бий болж эхэлсэн ба 2017 оны жилийн эцэст 104.2 тэрбум төгрөгийн хуримтлал байсан бөгөөд 2018 онд тус санд эрдэс баялгийн орлогоос 122.7 тэрбум төгрөг хуваарилагдахаар батлагдаж, гүйцэтгэл 207.0 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 68.6 хувиар буюу 84.2 тэрбум төгрөг илүү төвлөрсөн байна. 2018 оны жилийн эцсийн байдлаар Төсвийн тогтворжуулалтын сан 301.9 тэрбум төгрөгийн хуримтлалтай байна.

## 5. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогод 2018 онд эрүүл мэндийн даатгалын хураамжийн шимтгэлийн орлогоор 376.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 411.1 тэрбум төгрөг төвлөрч, 109.3 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

### Хүснэгт 19. ЭМДС-ийн төсөв /тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>376.0</b>	<b>411.1</b>	<b>35.1</b>
Татварын орлого	376.0	411.1	35.1
Нийгмийн даатгалын орлого	376.0	411.1	35.1
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>341.3</b>	<b>311.7</b>	<b>-29.6</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>341.3</b>	<b>311.7</b>	<b>-29.6</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4.0</b>	<b>3.4</b>	<b>-0.6</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1.4	1.3	-0.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.2	0.1	0.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.1	0.0	-0.1
Хангамж, бараа материалын зардал	0.1	0.1	0.0
Эд хогшил, урсгал засварын зардал	0.4	0.2	-0.1
Томилолт, зочны зардал	0.1	0.1	0.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1.5	1.3	-0.1
Бараа үйлчилгээний бусад зардал	0.2	0.1	-0.1
<b>ТАТААС</b>	<b>47.5</b>	<b>37.8</b>	<b>-9.7</b>
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	47.5	37.8	-9.7
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>289.8</b>	<b>270.6</b>	<b>-19.2</b>
Засгийн газрын урсгал шилжүүлэг	289.5	270.4	-19.2
Засгийн газрын дотоод шилжүүлэг	289.5	270.4	-19.2
Бусад урсгал шилжүүлэг	0.3	0.2	-0.1
Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	0.2	0.2	-0.1
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.0	0.0	0.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.0	0.0	0.0
<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>34.7</b>	<b>99.3</b>	<b>64.7</b>
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-34.7	-99.3	-64.7
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-34.7	-99.3	-64.7

Харин эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 2018 онд 311.7 тэрбум төгрөгт хүрч, нийт төлөвлөгөөний 91.3 хувьтай тэнцэж байна. Ингэснээр Эрүүл мэндийн даатгалын сан нь 2018 онд 99.3 тэрбум төгрөгийн ашигтай байна.

## 6. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ

Нийгмийн даатгалын сангийн орлогод 2018 онд 1,911.2 тэрбум төгрөг төлөвлөснөөс 2,090.1 тэрбум төгрөг төвлөрч, 109.4 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Нийгмийн даатгалын сангийн орлогуудаас нийгмийн даатгалын шимтгэл, хураамжийн төлбөрт 1,480.2 тэрбум төгрөг төвлөрч 113.7 хувийн биелэлттэй, улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг 609.8 тэрбум төгрөгт хүрч 100 хувийн биелэлттэй байна.

### Хүснэгт 20. НДС-ийн төсөв /тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>1,911.2</b>	<b>2,090.1</b>	<b>178.8</b>
<b>Татварын орлого</b>	<b>1,301.4</b>	<b>1,480.2</b>	<b>178.8</b>
Нийгмийн даатгалын орлого	1,301.4	1,480.2	178.8
<b>Татварын бус орлого</b>	<b>609.8</b>	<b>609.8</b>	<b>0.0</b>
Тусламжийн орлого	609.8	609.8	0.0
Хандив тусламж /дотоод/	609.8	609.8	0.0
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,808.3</b>	<b>1,814.6</b>	<b>6.4</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,808.3</b>	<b>1,814.6</b>	<b>6.4</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>18.8</b>	<b>18.4</b>	<b>-0.4</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	13.3	13.3	0.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1.6	1.6	0.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1.0	1.0	0.0
Хангамж, бараа материалын зардал	0.5	0.5	0.0
Эд хогшил, урсгал засварын зардал	0.1	0.1	0.0
Томилолт, зочны зардал	0.1	0.1	0.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1.9	1.7	-0.2
Бараа үйлчилгээний бусад зардал	0.3	0.2	-0.1
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,789.5</b>	<b>1,796.2</b>	<b>6.8</b>
Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.0	0.0	0.0
Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.0	0.0	0.0
Бусад урсгал шилжүүлэг	1,789.5	1,796.2	6.8
Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	1,788.8	1,795.6	6.8
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.2	0.2	0.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.4	0.4	0.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.0	0.0	0.0
<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>103.0</b>	<b>275.4</b>	<b>172.5</b>
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-103.0	-275.4	-172.5
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-103.0	-275.4	-172.5

Харин нийгмийн даатгалын сангийн зарлага 2018 онд 1,814.6 тэрбум төгрөгт хүрч, нийт төлөвлөгөөний 100.4 хувьтай тэнцэж байна. Ингэснээр Нийгмийн даатгалын сан нь 2018 онд 275.4 тэрбум төгрөгийн ашигтай байна.

## 7. ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

Орон нутгийн 2018 оны төсвийн гүйцэтгэлээр нийт орлого 2,769.3 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 3.7 хувь буюу 98.6 тэрбум төгрөгөөр илүү төвлөрсөн байна. Харин нийт зарлага 2,762.7 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 5.9 хувь буюу 172.6 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

### Хүснэгт 21. Орон нутгийн төсөв /тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>2,670.7</b>	<b>2,769.3</b>	<b>98.6</b>
<b>Татварын орлого</b>	<b>1,103.1</b>	<b>1,158.8</b>	<b>55.7</b>
Орлогын албан татвар	757.7	814.2	56.5
Хөрөнгийн албан татвар	122.8	141.2	18.4
<b>Бусад татвар, төлбөр, хураамж</b>	<b>222.6</b>	<b>203.4</b>	<b>-19.2</b>
Бусад нийтлэг төлбөр, хураамж	87.1	72.1	-15.0
Газрын төлбөр	68.8	66.8	-2.0
Байгалийн нөөц ашигласны төлбөр	58.2	56.8	-1.4
Бусад татвар	8.4	7.7	-0.8
<b>Татварын бус орлого</b>	<b>1,567.6</b>	<b>1,610.5</b>	<b>42.8</b>
Нийтлэг татварын бус орлого	176.4	216.8	40.5
Хөрөнгийн орлого	1.2	1.1	-0.1
Тусламжийн орлого	1.7	4.2	2.5
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,388.4	1,388.4	0.0
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,935.3</b>	<b>2,762.7</b>	<b>-172.6</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,325.8</b>	<b>2,264.2</b>	<b>-61.6</b>
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,530.4	1,497.6	-32.8
ТАТААС	105.2	103.3	-1.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	690.2	663.2	-27.0
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>574.3</b>	<b>474.0</b>	<b>-100.3</b>
<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>35.2</b>	<b>24.5</b>	<b>-10.7</b>
<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>-264.6</b>	<b>6.6</b>	<b>271.2</b>
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	264.6	-6.6	-271.2
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	204.9	-104.7	-309.6
<b>ЗГ-ын зээл</b>	<b>53.6</b>	<b>89.4</b>	<b>35.8</b>
Гадаад	53.6	89.4	35.8
Төслийн зээл	53.6	89.4	35.8
Шинээр авах	53.6	89.4	35.8
<b>Өмч хувьчлал</b>	<b>6.1</b>	<b>8.6</b>	<b>2.6</b>

Орон нутгийн орлогын 41.8 хувь татварын орлогоос, 58.2 хувь татварын бус орлогоос бүрдсэн байна. Татварын орлогын 70.3 хувь буюу 814.2 тэрбум төгрөг хувь хүний орлогын албан татвараар төвлөрсөн байна. Тайлант онд ХХОАТ-ын

буцаалтаар иргэдэд 41.9 тэрбум төгрөгийг олгосон байна. Бусад татвар, төлбөр, хураамжийн орлогоор 203.4 тэрбум төгрөг төвлөрсөн байна. Татварын бус орлогын 86.2 хувийг улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг /180.7 тэрбум/, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлэг /88.6 тэрбум/, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилт /1,119.1 тэрбум/ -ийн орлогууд бүрдүүлж байна.

Орон нутгийн нийт зарлага, санхүүжилтийн 82.0 хувь буюу 2,264.2 тэрбум төгрөгийг урсгал зардалд, үүнээс цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 929.8 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Хөрөнгийн зардлын гүйцэтгэл 474.0 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 100.3 тэрбум төгрөгөөр бага, өмнөх оны гүйцэтгэлээс 138.3 тэрбум төгрөгөөр их байна. Орон нутгийн төсвөөс улсын төсөвт 289.2 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна.

## 8. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР

Засгийн газрын өрийн үлдэгдэл 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 22,751.6 тэрбум төгрөг, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа 72.5 хувьтай тэнцэж байсан бол 2018 оны жилийн эцсийн байдлаар 22,367.0 тэрбум төгрөгт хүрч, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн үлдэгдлийг урьдчилсан ДНБ-д харьцуулсан харьцаа 58.9 хувьтай тэнцэж байна.

### Хүснэгт 22. Засгийн газрын өрийн үлдэгдэл, өрийн хэрэгслээр/тэрбум төгрөг/

ӨРИЙН БҮТЭЦ, ӨРИЙН ХЭРЭГСЭЛ	2017.12.31	2018.12.31
I. Засгийн газрын дотоод өр	3,461.9	1,564.7
1.1 Үнэт цаас	3,461.9	1,564.7
II. Засгийн газрын гадаад өр	16,857.8	18,865.6
2.1 Үнэт цаас	7,701.6	7,664.5
2.2 Зээл	9,156.2	11,201.1
III. Засгийн газрын өрийн баталгаа	1,663.7	1,130.7
IV. Барих-шилжүүлэх концесс	768.2	806.0
<b>ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР</b>	<b>22,751.6</b>	<b>22,367.0</b>
<b>ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)</b>	<b>20,212.1</b>	<b>18,955.9</b>
<b>Хуулиар тогтоосон өрийн хязгаар</b>	<b>85.0%</b>	<b>80.0%</b>
<b>Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ</b>	<b>72.5%</b>	<b>58.9%</b>

Засгийн газрын нийт өрийн багцын 7.0 хувийг дотоод өр, 84.3 хувийг Засгийн газрын гадаад зээл, үнэт цаас, 5.1 хувийг Засгийн газрын өрийн баталгаа, 3.6 хувийг барих-шилжүүлэх төрлийн концессын өр төлбөр эзэлж байна.

Засгийн газрын нийт гадаад өрийн 40.6 хувийг Засгийн газрын гадаад үнэт цаас бүрдүүлж байгаа бол 59.4 хувийг Засгийн газрын гадаад хөнгөлөлттэй болон арилжааны зээл тус тус эзэлж байна.

## 8.1. ЗАСГИЙН ГАЗРЫН ДОТООД ҮНЭТ ЦААС

Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл 2017 оны жилийн эцсийн байдлаар 3,461.9 тэрбум төгрөг байсан бол 2018 оны жилийн эцсийн байдлаар 1,564.7 тэрбум төгрөгт хүрч, 54.8 хувиар буураад байна.

**График 4. Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдлийн мэдээлэл /тэрбум төгрөг/**



Дотоод үнэт цаасны үлдэгдэл буурсан гол шалтгаан нь Засгийн газрын зүгээс 2017 оны 10 дугаар сараас Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг зогсоож 2018 онд шинээр арилжаалаагүйтэй холбоотой.

Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдлийн 68.1 хувийг улсын төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зориулалтаар гаргасан үнэт цаас, 8.0 хувийг хүний хөгжил сангийн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зориулалтаар гаргасан үнэт цаас, 23.9 хувийг Сайн хувьцаа хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор гаргасан үнэт цаас эзэлж байна.

Тайлант онд Засгийн газрын дотоод үнэт цаасны үндсэн төлбөрт 1,767.7 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 354.2 тэрбум төгрөгийг тус тус төлсөн. Үүнээс тусгай зориулалтын үнэт цаас буюу Сайн малчин, 4000 айлын орон сууц хөтөлбөрийн үнэт цаасны үндсэн төлбөрт 3.7 тэрбум төгрөгийг төлж үлдэгдэлгүй болсон бол улсын төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор арилжаалсан үнэт цаасны үндсэн төлбөрт 1,667.4 тэрбум төгрөг, Хүний хөгжил сангийн алдагдлыг нөхөх зорилгоор арилжаалсан үнэт цаасны үндсэн төлбөрт 96.6 тэрбум төгрөгийг тус тус төлсөн.

## 8.2. ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ҮНЭТ ЦААС

Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдэл 2017 оны эцэст 3,173.1 сая ам.доллар буюу 7,701.6 тэрбум төгрөг байсан бол 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар олон улсын зах зээлд нийт гаргасан Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдэл 2,900.0 сая ам.доллар буюу 7,664.5 тэрбум төгрөгт хүрээд байна.

Засгийн газрын зүгээс 2012 онд гаргасан 500.0 сая ам.долларын Чингис бонд, 2015 онд гаргасан 1.0 тэрбум юанийн ДимСам бондыг хугацаанд нь амжилттай төлж дуусгасан бөгөөд тайлант онд гадаад үнэт цаасны үндсэн төлбөрт 667.0 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт нийт 520.7 тэрбум төгрөгийг тус тус төлсөн.

### Хүснэгт 23. Засгийн газрын гадаад бондын 2018 оны үлдэгдэл

№	Гадаад үнэт цаас	Валют	Гаргасан дүн	Гаргасан огноо	Купон	Хугацаа	Үлдэгдэл 2018.12.31	
							USD	MNT / Тэрбум төгрөг
1	Чингис-500.0	USD	500\$	2012/12/05	4.125%	5	-	-
2	Чингис-1,000.0	USD	1000\$	2012/12/05	5.125%	10	1,000.0	2,642.9
3	Дим сам	CNY	1000¥	2015/06/30	7.500%	3	-	-
4	Мазаалай	USD	500\$	2016/04/06	10.875%	5	500.0	1,321.5
5	Хуралдай	USD	600\$	2017/03/09	8.750%	7	600.0	1,585.8
6	Гэрэгэ	USD	800\$	2017/10/26	5.625%	5.5	800.0	2,114.3
	НИЙТ						2,900.0	7,664.5

## 8.3. ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛ

Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл 2018 оны эцэст 11,201.1 тэрбум төгрөг байгаа бөгөөд зээлийн нийт үлдэгдлийн 84.5 хувийг Азийн хөгжлийн банк, Япон, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Дэлхийн банк гэсэн 4 том зээлдүүлэгчийн зээл эзэлж байна. Гадаад зээлийн үлдэгдэл нь нийт өрийн багцын 50.1 хувийг эзэлж байна. Тайлант хугацаанд нийт 1,490.5 тэрбум төгрөгийн гадаад зээлийн эх үүсвэрийг ашигласан /үүнээс төслийн зээл 1,015.4 тэрбум төгрөг, хөтөлбөрийн зээл 474.8 тэрбум төгрөг/ ба гадаад зээлийн үйлчилгээний төлбөрт 451.5 тэрбум төгрөг, үүнээс үндсэн төлбөрт 280.2 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 171.3 тэрбум төгрөгийг тус тус төлсөн байна.

Томоохон төсөл хөтөлбөрүүдийг авч үзвэл:

### Хүснэгт 24. Гадаад зээлийн эх үүсвэрийн ашиглалт / тэрбум төгрөг/

ТӨРӨЛ/ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН НЭР	Ашиглалт Т
<b>I. ТӨСЛИЙН ЗЭЭЛ</b>	<b>1,015.4</b>
Улаанбаатар-Мандалговь цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төсөл	141.9
Улаанбаатар-Хөшигтийн хөндийн шинэ нисэх онгоцны буудлын хурдны зам барих төсөл	75.3
Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын хөтөлбөр - Төсөл 2	74.4
Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км авто зам барих төсөл	55.9
Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.4 км автозам барих төсөл	52.2
Зээлийн баталгааны системийг бүрдүүлэх замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байр бий болгох	44.1
Улаанбаатар хотын шинэ олон улсын нисэх онгоцны буудал барих төсөл II	41.4
Улаанбаатар хотын 4-р цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төсөл	40.7
Үндэсний оношилгоо, эмчилгээний төв байгуулах төсөл	40.3
Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын шинэчлэл төсөл	38.9
Эрүүл мэндийн салбарын хөгжил төсөл V	37.4
Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх төсөл	33.9
Эрүүл мэндийн салбарын хөгжил төсөл IV нэмэлт санхүүжилт	28.5
Хөдөө аж ахуй болон хөдөөгийн хөгжлийг дэмжих төсөл	25.6
Яармагийн шинэ гүүр барих, хуучин гүүрийг засварлах төсөл	25.2
Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих төсөл	24.3
Төрийн тусгай албан хаагчдыг нэгдсэн эмнэлэг төсөл	20.1
Эрчим хүчний үр ашиг (Дарханы ДЦС-ын шинэчлэл)	17.7
Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр - төсөл 1(EIB)	14.6
Туул гол дээгүүр Баянзүрхийн 321 у/м болон Сонсголонгийн 289.4 у/м төмөр бетон гүүр шинээр барих	14.6
Зүүн өмнөд Говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл	14.2
Инженер технологийн дээд боловсрол төсөл	11.9
Тогтвортой амьжиргаа-3 төсөл	9.7
Орон сууцны хороолол, дэд бүтцийг хөгжүүлэх төсөл	8.9
Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл	8.5
Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр - Төсөл 1	8.2
Тайшир-Алтай ус хангамж төсөл	8.1
Хүнс, тэжээл нийгмийн халамжийн төсөл - Нэмэлт санхүүжилт	7.9
Бусад	91.2
<b>II. ХӨТӨЛБӨРИЙН ЗЭЭЛ</b>	<b>474.8</b>
Нийгмийн халамжийг дэмжих хөтөлбөр	128.2
Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдал төсөл	105.7
Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг дэмжих төсөл 2	240.9
<b>НИЙТ</b>	<b>1,490.3</b>

## 8.4. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАТАЛГАА

Засгийн газрын баталгааны үлдэгдэл 2017 оны эцэст 1,663.7 тэрбум төгрөг байсан бол 2018 оны жилийн эцсийн байдлаар 1,130.7 тэрбум төгрөг байна. Үүнээс Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК-ийн баталгааны үлдэгдэл 107.4



тэрбум төгрөг, Монгол Улсын Хөгжлийн банкны баталгааны үлдэгдэл 1,003.6 тэрбум төгрөг, Эрдэнэс Монгол ХК-ний баталгааны үлдэгдэл 19.7 тэрбум төгрөг байна.

### Хүснэгт 25. Засгийн газрын өрийн баталгааны 2018 оны үлдэгдэл

#	Баталгааны дугаар	Зээлдүүлэгч	Валют	Зээллэгийн огноо	Баталгаа гаргуулагч	2018.12.31			
						үндсэн валют /сая/	Тэрбум төгрөг	Сая USD	
<b>I. ЗАСГИЙН ГАЗРЫН ГАРГАСАН</b>									
1	DBM-580	Global Investors	USD	3/21/2012	МУХБанк	-	-	-	
2	MIAT-1	PEFCO	USD	12/24/2013	МИАТ ХК	34.6	91.6	34.6	
3	MIAT-2	ING Capital	USD	12/24/2013	МИАТ ХК	6.0	15.8	6.0	
4	MIAT-3	ING Bank N.V.	USD	12/24/2013	МИАТ ХК	-	-	-	
5	DBM-30	Japan Investors	JPY	1/6/2014	МУХБанк	30,000.0	718.2	271.7	
6	DBM-162	China Dev. bank	USD	9/3/2014	МУХБанк	108.0	285.4	108.0	
7	DBM-300	Credit Suisse	USD	9/5/2014	МУХБанк	-	-	-	
8	VTB-300	VTB	USD	6/15/2016	МУХБанк	-	-	-	
9	Gold-128	Голомт банк	MNT	5/1/2016	ГБНБ ХХК	-	-	-	
10	EM-35	ADB	USD	4/1/2016	Эрдэнэс Монгол ХХК	7.4	19.7	7.4	
<b>НИЙТ</b>							<b>1,130.7</b>	<b>427.8</b>	
<b>II. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСААР БАТАЛГААЖСАН</b>									
<b>1</b>	TDB-500 <sup>3</sup>	Олон улсын хөрөнгө оруулагч	USD	5/19/2015	ХХБ	500.0	1,321.5	500.0	

Худалдаа хөгжлийн банк нь эзэмшиж байсан 993.0 тэрбум төгрөгийн Засгийн газрын үнэт цаасыг барьцаалан баталгаа гаргуулсан бөгөөд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.3-т "Энэ хуулийн 6.1.4-т заасан Засгийн газрын өрийн хязгаарт Засгийн газрын дотоод үнэт цаасаар бүрэн баталгаажсан буюу барьцаа тавьсан өрийн баталгааны үлдэгдлийг оруулж тооцохгүй." гэж заасны дагуу 500.0 сая ам.долларын баталгааг Засгийн газрын баталгааны үлдэгдэлд оруулж тооцоогүй.

## 8.5. ТӨСВӨӨС ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙ КОНЦЕСС

<sup>3</sup> Засгийн газрын 2015 оны 163 дугаар тогтоолын дагуу Худалдаа хөгжлийн банкны 1.0 их наяд төгрөгийн дотоод үнэт цаасыг барьцаалан тус банкны олон улсын зах зээлд арилжаалсан 500.0 сая ам.долларын гадаад бондод өрийн баталгаа гаргасан бөгөөд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.3-т заасны дагуу Худалдаа хөгжлийн банканд гаргасан Засгийн газрын дотоод үнэт цаасаар баталгаажсан өрийн баталгаа нь өрийн үлдэгдэлд тооцогдохгүй байх зохицуулалттай.

Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.8 дахь хэсэгт заасны дагуу улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээ нь өрийн хэрэгсэлд тооцогдохоор хуульчилсан бөгөөд хуулийн 40.7 дахь хэсэгт “Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээг хүчин төгөлдөр болсон өдрөөр өрийн мэдээллийн нэгдсэн санд оруулж, концессын гэрээний дагуу улирал бүр гарсан ашиглалтыг үндэслэж Засгийн газрын өрд бүртгэнэ” гэж заасны дагуу Сангийн яам Концессын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (Үндэсний хөгжлийн газар) болон орон нутгийн Засаг захиргааны байгууллагуудаас холбогдох журам, маягтад заасны дагуу улирал бүр ашиглалт, гүйцэтгэлийн мэдээллийг авч, нэгтгэн Засгийн газрын өрд бүртгэж байна.

Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөх концессын үлдэгдэл 2017 оны эцэст 768.2 тэрбум төгрөг байсан бол 2018 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 806.0 тэрбум төгрөг байна. Үүнээс Улсын төсвөөс эргэн төлөгдөх нийт 23 гэрээний үлдэгдэл 803.5 тэрбум төгрөг, орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нийт 8 гэрээний үлдэгдэл 2.5 тэрбум төгрөг байна.

#### Хүснэгт 26: Барих-шилжүүлэх нөхцөлтэй концессын гэрээний үлдэгдэл

Барих-шилжүүлэх Концесс	Төслийн тоо	Гэрээний дүн	Үлдэгдэл
<b>Улсын төсөв</b>	<b>23</b>	<b>1,759.5</b>	<b>803.5</b>
Гүйцэтгэл 100%	13	524.7	290.9
Гүйцэтгэл 50-98%	4	594.1	442.0
Гүйцэтгэл 1-49%	6	640.7	70.7
<b>Орон нутаг</b>	<b>8</b>	<b>8.6</b>	<b>2.5</b>
Баянхонгор аймаг	1	3.7	0.5
Говь-Алтай аймаг	3	3.5	1.3
Завхан аймаг	1	0.5	0.1
Ховд аймаг	3	0.9	0.5
<b>НИЙТ</b>	<b>31</b>	<b>1,768.1</b>	<b>806.0</b>

--- о О о ---